



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 4/65

Булган сум

“Таван аваргын нэрэмжит” бөхийн барилдааныг зохион байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны IV Хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арван долоо дугаар жарны “Хөхөгчин Могой жил”-ийн сар шинийн баярыг тохиолдуулан “Таван аваргын нэрэмжит” улс, аймгийн цолтой 128 бөхийн барилдааныг Булган суманд 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсугай.

2. Зохион байгуулахад шаардагдах 31,516,000 (гучин нэгэн сая таван зуун арван зургаан мянга) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ГҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
... дугаар сарын ...-ны/ний өдрийн ... дүгээр
захирамжийн хавсралт

**“ТАВАН АВАРГЫН НЭРЭМЖИТ” УЛС, АЙМГИЙН ЦОЛТОЙ
128 БӨХИЙН БАРИЛДААНЫ ТӨСӨВ**

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1.	Түрүү бөхийн шагнал	1	10,000,000	10,000,000
2.	Үзүүр бөхийн шагнал	1	5,000,000	5,000,000
3.	Шөвгийн 4 бөхийн шагнал	2	2,000,000	4,000,000
4.	4 давсан бөхийн шагнал	4	500,000	2,000,000
Нийт			21,000,000	
1.	Ерөнхий хөлийн цэц /ажлын хөлс/	2	100,000	200,000
2.	Гарын даа /ажлын хөлс/	2	100,000	200,000
3.	Засуул /ажлын хөлс/	8	80,000	640,000
4.	Тайлбарлагч /ажлын хөлс/	1	1,500,000	1,500,000
5.	Лам /ном хурах ажлын хөлс/	2	100,000	200,000
Нийт			2,740,000	
Бусад				
1.	Хулдаасан хэвлэл /гадаа/	4x5	12,000	259,000
2.	Хулдаасан хэвлэл /дотор/	3x6	12,000	235,000
3.	Тасалбар хэвлэл /Хангай пресс/	800ш	700	560,000
4.	Өргөмжлөл	4	70,000	280,000
5.	Айраг	100л	10,000	1,000,000
6.	Медаль	4	18,000	72,000
7.	Шторк /хоолой уншуулах/	1	170,000	170,000
8	Улс, аймгийн цолтой бөхчүүдийн цай хоолны зардал /өглөө, өдөр, орой/	34	50,000	1,700,000
9	Улсын цолтой бөхчүүдэд хүндэтгэл үзүүлэх	7	500,000	3,500,000
Нийт			7,776,000	
Нийт дүн			31,516,000	